



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.18 № 52

Нагивацийн орлогын талаар
асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

1.Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоолын 8-д “Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор нагивацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах” гэж заасны дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөв, зориулалтын талаар болон улсын төсөвт сүүлийн 5 жилийн байдлаар нагивацаас хэдэн төгрөгийн орлогыг бүрдүүлсэн, мөн хуульд заасан шаардлагын дагуу зарцуулсан тайлан, хүрсэн үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.Цаашид нагивацийн орлогоос гадна зорчигчдоос буюу user charge (safety fee) авдаг олон улсын санхүүгийн зарчмаар санхүүжих боломжтой эсэх талаар бодлогын ямар байр суурь баримталж байгаа талаарх мэдээллийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацааны дотор ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

2025000085